

Санхүүгийн зохицуулах хорооны 2023
оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн
559 дүгээр тогтоолын хавсралт

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан
“Даатгалын багц дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт

ДААТГАГЧИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь даатгагч даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгөтэй эсэхийг тодорхойлох, төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, зохистой харьцааг эрсдэлд суурилсан хөрөнгийн аргачлалаар тооцоолох, тайлагнах, түүнд Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Даатгагч төлбөрийн чадварын зохистой харьцаанд нөлөөлж болзошгүй дараах эрсдэлүүдийн хүрээнд холбогдох үзүүлэлтийг авч үзнэ. Үүнд:

1.2.1.Зах зээлийн эрсдэл буюу зах зээл дээрх хөрөнгө, санхүүгийн хэрэгслийн зах зээлийн үнийн өөрчлөлтийн улмаас даатгагчийн санхүүгийн байдалд учрах сөрөг нөлөөлөл /Уг эрсдэлд хүүгийн эрсдэл, валютын ханшийн эрсдэл, хувьцааны эрсдэл, хөрөнгийн эрсдэлийг авч үзнэ/;

1.2.2.Зээлийн эрсдэл буюу харилцагч этгээдийн төлбөр төлөх чадвар алдагдсаны улмаас даатгагчийн хөрөнгийн дүн буурах эрсдэл /Уг эрсдэлд дотоодын банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, даатгалын авлага, давхар даатгагчаас авах авлага, бусад авлага, гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, хойшлогдсон давхар даатгалын хураамж, нөхөн төлбөрийн нөөцийн сангийн давхар даатгагчид ногдох хэсэг, даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардал, үнэт цаас болон бусад үзүүлэлттэй холбогдох эрсдэлийг авч үзнэ/;

1.2.3.Андеррайтингийн эрсдэл буюу даатгалын хураамж, нөөц зэргийг хангалттай тооцоогүйн улмаас даатгагчийн өр төлбөрийн хэмжээ багаар тооцогдох эрсдэлийг даатгалын ангиллаас хамааран дараах үзүүлэлтүүдийн хүрээнд тооцоолно. Үүнд:

1.2.3.1.Ердийн даатгалын хувьд хураамжийн эрсдэл болон нөхөн төлбөрийн эрсдэл;

1.2.3.2.Урт хугацааны даатгалын хувьд нас баралтын, насжилтын, гэрээ цуцлалтын, зардлын болон гамшгийн эрсдэл;

1.2.4.Үйл ажиллагааны эрсдэл буюу дотоод үйл ажиллагаатай холбоотойгоор учрах эрсдэл;

1.2.5.Бусад шаардлагатай үзүүлэлт.

1.3.Даатгагч төлбөрийн чадварын зохистой харьцааг эрсдэлд суурилсан хөрөнгийн аргачлалаар тооцоолохдоо гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулсан санхүүгийн тайлан, тэнцлийн үзүүлэлтүүдийг ашиглана.

1.4.Даатгагч эрсдэлд суурилсан хөрөнгийн аргачлалаар төлбөрийн чадварын зохистой харьцааны тооцоолол хийх, түүний тайлан болон шаардлагатай тохиолдолд төлөвлөгөө боловсруулах ажилтныг томилсон байна.

Хоёр. Эрсдэлд суурилсан хөрөнгийн аргачлалаар тооцсон төлбөрийн чадварын зохистой харьцаа

2.1. Даатгагч төлбөрийн чадварын зохистой харьцааг эрсдэлд суурилсан хөрөнгийн аргачлалаар тодорхойлохдоо тоон үзүүлэлт буюу даатгагчийн хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа болон чанарын үзүүлэлт буюу даатгагчийн зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн харьцаа үзүүлэлтүүдийг тооцоолно.

2.2. Хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцааг даатгагчийн өөрийн хөрөнгийн дүнг зайлшгүй байх хөрөнгийн дүнд хуваах замаар буюу дараах томъёогоор тооцно:

$$\text{ХХБХ} (\%) = \text{ДӨХ} / \text{ЗБХ} * 100. \text{ Үүнд:}$$

ХХБХ – хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа;

ДӨХ – даатгагчийн өөрийн хөрөнгийн дүн;

ЗБХ – зайлшгүй байх хөрөнгийн дүн.

2.3. Ердийн даатгагчийн өөрийн хөрөнгийн дүнг даатгагчийн нийт хөрөнгийн дүнгээс даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардлын болон нийт өр төлбөрийн дүнг хасаж, тусгай нөөц сангийн дүнг нэмэх замаар буюу дараах томъёогоор тооцно:

$$\text{ДӨХ} = \text{ДНХ} - \text{ДОХШЗ} - \text{НӨТ} + \text{ТНС}. \text{ Үүнд:}$$

ДНХ – даатгагчийн нийт хөрөнгийн дүн /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн/;

ДОХШЗ – даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардлын дүн /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардлын дүн/;

НӨТ – нийт өр төлбөрийн дүн /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нийт өр төлбөрийн дүн/;

ТНС – тусгай нөөц сангийн дүн /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн тусгай нөөц сангийн дүн/.

2.4. Давхар даатгагчийн өөрийн хөрөнгийн дүнг даатгагчийн нийт хөрөнгийн дүнгээс даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардлын болон нийт өр төлбөрийн дүнг хасаж, алдагдлаас хамгаалах сангийн дүнг нэмэх замаар буюу дараах томъёогоор тооцно:

$$\text{ДӨХ} = \text{ДНХ} - \text{ДОХШЗ} - \text{НӨТ} + \text{АХС}. \text{ Үүнд:}$$

ДНХ – даатгагчийн нийт хөрөнгийн дүн /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн/;

ДОХШЗ – даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардлын дүн /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардлын дүн/;

НӨТ – нийт өр төлбөрийн дүн /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нийт өр төлбөрийн дүн/;

АХС – алдагдлаас хамгаалах сангийн дүн /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн алдагдлаас хамгаалах сангийн дүн/.

2.5. Урт хугацааны даатгагчийн өөрийн хөрөнгийн дүнг даатгагчийн нийт хөрөнгийн дүнгээс нийт өр төлбөрийн дүнг хасах замаар буюу дараах томъёогоор тооцно:

$$\text{ДӨХ} = \text{ДНХ} - \text{НӨТ}. \text{ Үүнд:}$$

ДНХ – даатгагчийн нийт хөрөнгийн дүн /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн/;

НӨТ – нийт өр төлбөрийн дүн /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нийт өр төлбөрийн дүн/.

2.6.Энэ журмын 2.2-т заасан зайлшгүй байх хөрөнгийн дүнг даатгагчийн үйл ажиллагаанаас хамааран дараах байдлаар тооцно. Үүнд:

2.6.1.Ердийн болон давхар даатгагчийн хувьд эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн болон Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ (дүрмийн сан)-ний аль ихээр буюу дараах томъёогоор тооцно:

$$ЗБХ = \max (\text{ЭСХ}; \text{ХНХДХ}). \text{ Үүнд:}$$

ХНХДХ – Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ;

ЭСХ – эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн.

2.6.2.Урт хугацааны даатгагчийн хувьд эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнгийн 150 хувьтай тэнцэхүйц хэмжээгээр буюу дараах томъёогоор тооцно:

$$ЗБХ = 3.5 * \text{ЭСХ}.$$

2.7.Даатгагчийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг даатгагчийн үйл ажиллагаа явуулахад гарч буй эрсдэл, үзүүлэлт тус бүрээр тооцсон эрсдэлд суурилсан хөрөнгийн нийлбэр дүнгээс төрөлжүүлэлтийн бууруулалтын дүнг хасах замаар буюу дараах томъёогоор тооцно:

$$\text{ЭСХ} = (33Э + ЗЭ + АЭ + \text{ҮАЭ} + Б) - \text{ТБ}. \text{ Үүнд:}$$

33Э – зах зээлийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн;

ЗЭ – зээлийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн;

АЭ – андеррайтингийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн;

ҮАЭ – үйл ажиллагааны эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн;

Б – бусад шаардлагатай үзүүлэлтүүдийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн (тодорхой зааж тусгаагүй тохиолдолд 0-тэй тэнцүү байна);

ТБ – төрөлжүүлэлтийн бууруулалтын дүн.

2.8.Зах зээлийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг тооцохдоо энэ журмын гуравдугаар хавсралтад заасан эрсдэл тус бүрээрх эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг харгалзах хамаарлын коэффициентээр үржүүлэн гарган авсан дүнгүүдийн нийлбэрийг ашиглан дараах томъёогоор тооцно:

$$33Э = \sqrt{\sum_{ij} 33Э\text{Коэф}_{ij} * \text{Э}_i * \text{Э}_j}. \text{ Үүнд:}$$

$33Э\text{Коэф}_{ij}$ – энэ журмын гуравдугаар хавсралтад заасан i, j дугаар эрсдэлд харгалзах хамаарлын коэффициент;

$\text{Э}_i, \text{Э}_j$ – энэ журмын гуравдугаар хавсралтад заасан эрсдэл тус бүрээрх i, j дугаар эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн.

2.9.Зах зээлийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг тооцоход дараах зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:

2.9.1.Энэ журмын гуравдугаар хавсралтад заасан зах зээлийн эрсдэлд хамаарах эрсдэл тус бүрээрх эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг энэ журмын нэгдүгээр хавсралтад заасны дагуу тухайн эрсдэлийн ангилал дахь хөрөнгийн дүнг харгалзах эрсдэлийн хувиар үржүүлж тооцно;

2.9.2.Энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан 1-5 жилийн хугацаатай, 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай байршуулсан хөрөнгө, хөрөнгө оруулалтын хүүгийн эрсдэлийн хувийг энэ журмын хоёрдугаар хавсралтын дагуу тооцсон даатгагчийн хөрөнгө, өр төлбөрийн хугацааны зөрүүгээс хамааран тогтооно;

2.9.3.Энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан хүүгийн болон валютын ханшийн эрсдэлийн хувийг даатгалын мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн нийгэм, эдийн засгийн нөхцөл

байдлыг харгалзан үзэж, шаардлагатай тохиолдолд Хорооны даргын тушаалаар шинэчлэн баталж болно;

2.9.4.Энэ журмын нэгдүгээр хавсралтад тусгагдсан өмчлөх бусад хөрөнгийг өмчлөлд авснаас хойших хугацаанаас эхлэн дараах хүснэгтийн дагуу хугацааг тооцож, ангилна.

Ангилал	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Хугацааны үзүүлэлт	Өмчлөлд авснаас хойш 30 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 31-60 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 61-90 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 91-120 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 121 хоногоос дээш хугацаанд борлогдоогүй

2.10.Зээлийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг тооцоходоо энэ журмын тавдугаар хавсралтад заасан үзүүлэлт тус бүрээрх эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг харгалзах хамаарлын коэффициентоор үржүүлэн гарган авсан дүнгүүдийн нийлбэрийг ашиглан дараах томъёогоор тооцно:

$$ЗЭ = \sqrt{\sum_{ij} ЗЭКэф_{ij} * Y_i * Y_j}. \text{ Үүнд:}$$

$ЗЭКэф_{ij}$ – энэ журмын тавдугаар хавсралтад заасан i, j дугаар үзүүлэлтэд харгалзах хамаарлын коэффициент;

Y_i, Y_j – энэ журмын тавдугаар хавсралтад заасан үзүүлэлт тус бүрээрх i, j дугаар эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг.

2.11.Зээлийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг тооцоход дараах зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:

2.11.1.Энэ журмын тавдугаар хавсралтад заасан зээлийн эрсдэлд хамаарах үзүүлэлт бүрээрх эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг энэ журмын дөрөвдүгээр хавсралтад заасны дагуу тухайн үзүүлэлтийн ангилал дахь хөрөнгийн дүнг харгалзах эрсдэлийн хувиар үржүүлж тооцно;

2.11.2.Энэ журмын дөрөвдүгээр хавсралтад тусгагдсан авлагыг төлөхөөр тохиролцсон огноо буюу бичгээр хийсэн хэлцэлд тусгагдсан төлөгдөх хугацаа дууссанаас хойших хугацаанаас эхлэн дараах хүснэгтийн дагуу хугацааг тооцож, ангилна (авлагын төлөгдөх хугацааг 1 удаа 120 хүртэлх хоногоор сунгасан тохиолдолд тухайн авлагыг хэвийн авлагаар, 1 удаа 121-ээс дээш хоногоор сунгасан тохиолдолд эргэлзээтэй авлагаар, эсхүл 2 ба түүнээс дээш удаа авлагын төлөгдөх хугацааг сунгасан тохиолдолд тухайн авлагыг эргэлзээтэй авлагаар тооцно. Эргэлзээтэй авлагаар тооцож эхэлснээс хойш 30 хоногийн дотор төлөгдөөгүй бол тухайн авлагыг муу авлагаар тооцно);

Ангилал	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Хугацааны үзүүлэлт	Төлөгдөх хугацаа дууссанаас хойш 30 хүртэл хоногийн дотор байгаа	Төлөгдөх хугацаа дууссанаас хойш 31-60 хоногийн дотор төлөгдөөгүй	Төлөгдөх хугацаа дууссанаас хойш 61-90 хоногийн дотор төлөгдөөгүй	Төлөгдөх хугацаа дууссанаас хойш 91-120 хоногийн дотор төлөгдөөгүй	Төлөгдөх хугацаа дууссанаас хойш 121-ээс дээш хоногоор төлөгдөөгүй болон гэмт хэргийн улмаас бий болсон авлага

2.11.3.Энэ журмын дөрөвдүгээр хавсралтад заасан шаардлагыг хангасан дотоодын банк, санхүүгийн байгууллагын зээлжих/санхүүжих чадавхын зэрэглэлийг энэ журмын арван зургаадугаар хавсралтад тусгагдсан хүснэгтүүдийн дагуу ангилна.

2.11.4.Энэ журмын дөрөвдүгээр хавсралтад заасан гадаад улсын хуулийн этгээд/хөрөнгө оруулалтын зээлжих зэрэглэлийг энэ журмын арван долоодугаар хавсралтад тусгагдсан хүснэгтийн дагуу ангилах ба дараах тохиолдолд үндэслэл тайлбар, холбогдох судалгаа, нотлох баримтыг Хороонд ирүүлнэ. Үүнд:

2.11.4.1.хуулийн этгээд/хөрөнгө оруулалт нь уг хүснэгтэд тусгагдаагүй олон улсын буюу гадаад улсын албан ёсны зэрэглэл тогтоох байгууллагаас тогтоосон зэрэглэлтэй бол хүснэгтэд тусгагдсан зээлжих зэрэглэлүүдтэй харьцуулан, дүйцүүлж зээлийн эрсдэлийн тооцоололд ашиглагдах зээлжих зэрэглэлийн ангиллыг тогтооно. Хороо ирүүлсэн баримт материалд үндэслэн зэрэглэлийн ангиллыг өөрчилж болно;

2.11.4.2.хуулийн этгээд/хөрөнгө оруулалт нь батлан даалттай /guaranteed/, зэрэглэлгүй, хамгаалалттай /unrated, secured/ ангилалд хамаарах бол.

2.11.5.Энэ журмын 2.11.4-т заасан тайлбар, судалгаа, баримтыг ирүүлээгүй буюу ирүүлсэн баримт материал бүрэн бус, үндэслэлгүй, нотлогдох боломжгүй тохиолдолд уг хуулийн этгээд/хөрөнгө оруулалтыг зэрэглэлгүй, хамгаалалтгүй ангилалд авч үзнэ.

2.12.Андеррайтингийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг ердийн даатгалын хувьд энэ журмын 1.2.3.1-д заасан, урт хугацааны даатгалын хувьд энэ журмын 1.2.3.2-т заасан эрсдэл тус бүрээрх эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг тус тус энэ журмын долоодугаар, есдүгээр хавсралтад заасан харгалзах хамаарлын коэффициентоор үржүүлэн гарган авсан дүнгүүдийн нийлбэрийг ашиглан дараах томъёогоор тооцно:

$$AЭ = \sqrt{\sum_{ij} AЭКэф_{ij} * Э_i * Э_j}. \text{ Үүнд:}$$

$AЭКэф_{ij}$ – энэ журмын долоодугаар, есдүгээр хавсралтад заасан i, j дугаар эрсдэлд харгалзах хамаарлын коэффициент;

$Э_i, Э_j$ – энэ журмын 1.2.3.1, 1.2.3.2-т заасан эрсдэл тус бүрээрх энэ журмын долоодугаар, есдүгээр хавсралтад заасан i, j дугаар эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн.

2.13.Андеррайтингийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг тооцоход дараах зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:

2.13.1.Энэ журмын долоодугаар хавсралтад заасан хураамжийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг энэ журмын зургаадугаар хавсралтад заасны дагуу даатгалын хэлбэр тус бүрийн хувьд учирч болзошгүй хохирлын нөөц сан болон орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн нийлбэр дүнгээс давхар даатгагчид ногдох хэсгийг хасаж, харгалзах эрсдэлийн хувиар үржүүлж тооцно. Харгалзах эрсдэлийн хувийг энэ журмын арван наймдугаар хавсралтад заасан аргачлалын дагуу тооцоолсон байна;

2.13.2.Энэ журмын долоодугаар хавсралтад заасан нөхөн төлбөрийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг энэ журмын зургаадугаар хавсралтад заасны дагуу даатгалын хэлбэр тус бүрийн хувьд учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан болон мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сангуудын нийлбэр дүнгээс эдгээр нөөц сангуудын давхар даатгагчид ногдох хэсгийг хасаж, харгалзах эрсдэлийн хувиар үржүүлж тооцно. Харгалзах эрсдэлийн хувийг энэ журмын арван есдүгээр хавсралтад заасан аргачлалын дагуу тооцоолсон байна;

2.13.3.Энэ журмын есдүгээр хавсралтад заасан урт хугацааны даатгалын андеррайтингийн эрсдэл тус бүрийн хувьд энэ журмын наймдугаар хавсралтад заасны дагуу даатгалын хэлбэрээр

ангилан эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг тодорхойлно. Тус эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг энэ журамд заасан дараах шаардлагыг хангасан, даатгагч өөрийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний онцлогт тохируулан боловсруулсан аргачлалын дагуу тооцоолох бөгөөд аргачлалыг жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлж танилцуулсны үндсэн дээр өөрчилж болно. Үүнд:

2.13.3.1. даатгагчийн үйл ажиллагааны онцлог, бизнес төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын бодлогод нийцсэн байх буюу энэ талаарх тайлбар, судалгааг агуулсан байх;

2.13.3.2. даатгалын хэлбэр, түүнд хамаарах даатгалын бүтээгдэхүүн бүрийн хувьд хувь хүн, бүлгийн даатгал эсэх, жил бүр хураамж шинэчлэгдэх эсэх, хувь оролцоотой, хувь оролцоогүй, хөрөнгө оруулалттай холбоотой гэрээ эсэхийг ялгасан байдлаар эрсдэлийг тооцоолохоор тусгасан байх;

2.13.3.3. дундаж нас баралтын хувь, дундаж нас баралтын өсөлтийн хувь, гэрээ цуцлалтын дундаж түвшин, зардлын инфляцийн түвшин зэрэг тухайн эрсдэлд хамаарах үзүүлэлтүүдийг харгалзан үзсэн байх;

2.13.3.4. энэ журмын есдүгээр хавсралтад заасан эрсдэлүүд, түүнд хамаарах энэ журмын 2.13.3.3-т заасан үзүүлэлт, хүчин зүйлсийг хэрхэн тооцоолсон болон аргачлалд хамрагдаагүй эрсдэл, хязгаарлалт, давхар даатгалын нөлөөлөл, эрсдэлийг бууруулах хүчин зүйлсийн талаар тайлбар, судалгааг агуулсан байх.

2.13.4. Давхар даатгагчийн хувьд андеррайтингийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг ердийн болон урт хугацааны даатгалын эрсдэлд суурилсан хөрөнгийн нийлбэр дүнгээр тооцно;

2.13.5. Энэ журмын арван наймдугаар, арван есдүгээр хавсралтад заасан ерөнхий үзүүлэлтүүд буюу хохирлын харьцаа, нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт зэрэг үзүүлэлтүүдийн хүрээнд андеррайтингийн эрсдэлийн хувийг дараах шаардлагыг хангасан тоо мэдээлэл, аргачлалын дагуу даатгагч өөрийн үйл ажиллагааны онцлог болон тухайн ерөнхий үзүүлэлтүүдийн дүнг харгалзан тооцоолж болно. Уг тооцооллыг жилд нэг удаа, жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлж танилцуулсны үндсэн дээр эрсдэлийн хувиудыг өөрчилж болно. Үүнд:

2.13.5.1. тоо мэдээлэл нь үндсэн эрсдэлийн шинж чанарыг үнэлэх, тодорхойлоход хангалттай түүхэн мэдээллийг агуулдаг байх /дор хаяж 30 улирлын тоо мэдээллийг ашигласан байх/;

2.13.5.2. тоо мэдээллүүд нэг төрлийн эрсдэлийн бүлэгт хамаарах бөгөөд холбогдох тоо мэдээллийг үндэслэлгүйгээр хасаагүй байх;

2.13.5.3. тоо мэдээлэл үнэн зөв, тохиромжтой байх;

2.13.5.4. тоо мэдээллийг цаг тухайд нь дэс дараалалтайгаар тогтмол бүртгэсэн байх;

2.13.5.5. тоо мэдээлэл нь тооцоололд ашигласан актуар ба статистикийн аргуудын үндэс суурьтай нийцэж байх;

2.13.5.6. тоо мэдээллийг баримтжуулж, ил тод, тодорхой бүтэц зохион байгуулалттайгаар цуглуулж, боловсруулж, ашигласан байх;

2.13.5.7. Эрсдэлийн хувийг тооцоолохдоо ашиглаж буй тархалтыг статистикийн хувьд ач холбогдолтой буюу зохистой байдлыг дор хаяж дараах үзүүлэлтүүдийн хүрээнд шалгах. Үүнд:

2.13.5.7.1. Вариацийн коэффициент /coefficient of variation/;

2.13.5.7.2. Тархалтын налалтын коэффициент /skewness/;

2.13.5.7.3.Куртосис коэффициент /kurtosis/;

2.13.5.7.4.Тархалтын зураг /distribution graphic/;

2.13.5.7.5.Нийцэл, найдвартай байдал /goodness of fit - r^2 , BIC гэх мэт/;

2.13.5.8.Value at Risk /VaR/ утгыг тоо мэдээллийн хангалттай байдал, тархалтын онцлог, даатгалын эрсдэл зэргийг тус тус үндэслэн 95 ба түүнээс дээш, боломжит дээд хувийн итгэх түвшинд сонгох.

2.14.Үйл ажиллагааны эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг дараах томъёогоор тооцох бөгөөд даатгагчийн үйл ажиллагаанаас хамааран “ҮА” үзүүлэлтийг ялгаатай хэрэглэнэ.

$$ҮАЭ = ҮА * Э(\%). \text{ Үүнд:}$$

Э(%) – эрсдэлийн хувь /энэ журмын аравдугаар хавсралтад заасан даатгагчийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээний хувь/

2.14.1.Ердийн даатгагчийн хувьд “ҮА” үзүүлэлтийг орлогод тооцоогүй хураамжийн нөөц, учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан, мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан болон учирч болзошгүй хохирлын нөөц сангийн нийлбэр дүнгээр тооцно (Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нөөц сангийн дүнгээс тусгай нөөц сангийн дүнг хасаж, орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн дүнг нэмсэн дүн).

2.14.2.Урт хугацааны даатгагчийн хувьд “ҮА” үзүүлэлтийг хувь оролцоотой гэрээний нөөц сан, хувь оролцоогүй гэрээний нөөц сан, хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сангуудын нийлбэр дүн болон хөрөнгө оруулалттай холбоотой гэрээнд хамаарах зардлын дүнг ашиглан дараах томъёогоор тооцно:

$$ҮА = НС + 0.25 * ХОЗ. \text{ Үүнд:}$$

НС - хувь оролцоотой гэрээний нөөц сан, хувь оролцоогүй гэрээний нөөц сан, хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сангуудын нийлбэр дүн (Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нөөц сангийн дүн);

ХОЗ – хөрөнгө оруулалттай холбоотой гэрээнд хамаарах зардлын дүн /Тухайн хөрөнгө оруулалтын өртгийн дүн үүнд хамаарахгүй/.

2.14.3. Давхар даатгагчийн хувьд “ҮА” үзүүлэлтийг орлогод тооцоогүй хураамжийн нөөц, хамтын эрсдэлийн сан, эрсдэлээс хамгаалах сан, учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан, мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан, учирч болзошгүй хохирлын нөөц сан болон бусад нөөц сангийн нийлбэр дүнгээр тооцно (Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нөөц сангийн дүнгээс алдагдлаас хамгаалах сангийн дүнг хасаж, орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн дүнг нэмсэн дүн).

2.15.Төрөлжүүлэлтийн бууруулалтыг энэ журмын 2.8, 2.10, 2.12-т заасны дагуу тооцсон зах зээлийн, зээлийн болон андеррайтингийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг ашиглан энэ журмын арван нэгдүгээр хавсралтыг ашиглах буюу дараах томъёогоор тооцно:

$$ТБ = 3ЗЭ + 3Э + АЭ - \sqrt{3ЗЭ^2 + 3Э^2 + АЭ^2}.$$

2.16.Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн харьцааг энэ журмын 2.17-д заасан нийт зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүнг даатгагчийн нийт хөрөнгөөс хойшлогдсон давхар даатгалын хураамж, нөхөн төлбөрийн нөөцийн сангийн давхар даатгагчид ногдох хэсгийг хассан дүнд хуваах замаар буюу дараах томъёогоор тооцно:

$$ЗХХ(\%) = 3Х / (ДНХ - ХДДХ - НТНДДНХ) * 100. \text{ Үүнд:}$$

ЗХХ – зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн харьцаа

ЗХ – нийт зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүн

ДНХ – даатгагчийн нийт хөрөнгийн дүн /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн/

ХДДХ – хойшлогдсон давхар даатгалын хураамжийн дүн /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн хойшлогдсон давхар даатгалын хураамжийн дүн/

НТНДДНХ – нөхөн төлбөрийн нөөцийн сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн дүн /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нөхөн төлбөрийн нөөцийн сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн дүн/

2.17. Нийт зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүнг энэ журмын арван гуравдугаар хавсралтад заасны дагуу дараах үзүүлэлтүүдийн нийлбэрээр тооцно. Үүнд:

2.17.1. Хэвийн даатгалын авлага – 15 хувь;

2.17.2. Хэвийн даатгалын авлагаас бусад бүх авлага (цэвэр) – 100 хувь;

2.17.3. Урьдчилж төлсөн зардал, тооцоо – 100 хувь;

2.17.4. Хойшлогдсон татварын хөрөнгө – 100 хувь;

2.17.5. Бараа материал – 100 хувь;

2.17.6. Гүүдвил – 100 хувь;

2.17.7. Программ хангамж (цэвэр) – 50 хувь;

2.17.8. Бусад биет бус хөрөнгө (цэвэр) – 80 хувь;

2.17.9. Энэ журмын арван хоёрдугаар хавсралтын дагуу тооцсон нэгжид ногдох хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгийн нийлбэр дүн – 100%;

2.17.10. Даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтад заасан холбогдох этгээдэд байршуулсан хөрөнгө, хөрөнгө оруулалтын нийлбэр дүн – 80%.

2.18. Энэ журмын 2.1-д заасан хөрөнгийн хүрэлцээт байдлын байвал зохих доод харьцааг даатгагчийн эрсдэлд суурилсан хөрөнгө болон хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнг ашиглан дараах томъёогоор тооцно:

$$\text{ХХББЗДХ (\%)} = \max (1.5 * \text{ЭСХ}; \text{ХНХ}) / \text{ХНХ} * 100. \text{ Үүнд:}$$

ХХББЗДХ – Хөрөнгийн хүрэлцээт байдлын байвал зохих доод харьцаа

ЭСХ – Эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн

ХНХ – даатгагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн эзэмшигчдийн өмчийн дүн/

2.19. Энэ журмын 2.1-д заасан даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааг хангаж буй эсэхийг энэ журмын арван тавдугаар хавсралтын дагуу тодорхойлж, даатгагчийн төлбөрийн чадварыг дараах 5 түвшинд хувааж авч үзнэ. Үүнд:

2.19.1. Нэгдүгээр түвшин буюу даатгагчийн төлбөрийн чадвар сайн;

2.19.2. Хоёрдугаар түвшин буюу даатгагчийн төлбөрийн чадвар хангалттай;

2.19.3. Гуравдугаар түвшин буюу даатгагчийн төлбөрийн чадвар эргэлзээтэй;

2.19.4. Дөрөвдүгээр түвшин буюу даатгагч төлбөрийн чадваргүй болж болзошгүй;

2.19.5. Тавдугаар түвшин буюу даатгагч төлбөрийн чадваргүй.

2.20. Даатгагчийн төлбөрийн чадварын түвшин энэ журмын 2.19-д заасан дөрөв, тавдугаар түвшинд байгаа тохиолдолд тухайн даатгагчийг төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг хангаж чадахгүй байна гэж үзнэ.

Гурав. Тайлан, мэдээлэл

3.1. Даатгагч нь энэ журмын хавсралт маягтуудын дагуу төлбөрийн чадварын зохистой харьцааны тайланг гаргаж, улирал бүр санхүүгийн тайлангийн хамт цаасаар болон цахим хэлбэрээр Хороонд хүргүүлнэ. Төлбөрийн чадварын зохистой харьцааны тайлан нь энэ журмын хавсралт маягтуудаас бүрдэнэ.

3.2. Хороо энэ журмын 3.1-д заасан тайланг гаргахад шаардлагатай дараах нэмэлт тайлангийн маягтыг боловсруулах бөгөөд даатгагч энэхүү нэмэлт тайланг маягт, зааврын дагуу үнэн зөв бөглөж, энэ журмын 3.1-д заасан тайлангийн хамт Хороонд цахим хэлбэрээр хүргүүлнэ. Үүнд:

3.2.1. СЗХ04155а. Банкинд байршуулсан хөрөнгө /дотоод/;

3.2.2. СЗХ04155б. Банкнаас бусад санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө /дотоод/;

3.2.3. СЗХ04155в. Үнэт цаас /дотоод/;

3.2.4. СЗХ04155г. Гадаад улсад байршуулсан хөрөнгө;

3.2.5. СЗХ04155д. Өмчлөх бусад хөрөнгө, санхүүгийн түрээс;

3.2.6. СЗХ04155е. Валютын ханшийн эрсдэлд хамаарах хөрөнгө;

3.2.7. СЗХ04155ж. Даатгагчийн өр төлбөр хугацааны ангиллаар;

3.2.8. СЗХ04155з. Зээл, өрийн бичиг;

3.2.9. СЗХ04158а. Авлага;

3.2.10. СЗХ04158б. Давхар даатгалтай холбогдох хөрөнгө, даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардал;

3.2.11. СЗХ04162а. Урт хугацааны даатгалын андеррайтингийн эрсдэлийн бүтэц;

3.2.12. СЗХ04166а. Нэгжид ногдох хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгийн тооцоолол.

3.3. Даатгагч нь энэ журмын хорин дөрөвдүгээр хавсралт “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар”-ын дагуу өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлж, холбогдох баримт бичгийг зааварт заасан хугацаанд Хороонд ирүүлнэ.

3.4. Энэ журмын 3.1-д заасан даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны тайлан нь энэ журмын хорин дөрөвдүгээр хавсралт “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар”-т тусгасан даатгагчийн өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээний тайлангийн бүрдэл хэсэг болно.

3.5. Хороо шаардлагатай гэж үзвэл төлбөрийн чадварын зохистой харьцааны тайлан, энэ журмын 4.1.2, 4.1.3-т заасан төлөвлөгөөтэй холбогдуулан нэмэлт мэдээлэл, материал шаардаж болно.

3.6. Даатгагч энэ журмын 3.1, 3.2, 3.3, 3.4-т заасан тайлан, баримт бичгийг үндэслэл бүхий тоо мэдээлэл, баримт материалд тулгуурлан гаргах бөгөөд тэдгээрийн үндэслэлийг баримтаар баталгаажуулж, нотолсон байх шаардлагатай.

3.7. Даатгагч нь шаардлагатай гэж үзвэл энэ журмын 3.1-д зааснаас гадна төлбөрийн чадварын зохистой харьцааг тухай бүрд тооцоолох боломжтой байна.

3.8. Даатгагч энэ журмын 3.1, 3.7-д заасны дагуу төлбөрийн чадварын зохистой харьцааг тооцоолох үед даатгагчийн төлбөрийн чадварын түвшин энэ журмын 2.19.2 – 2.19.5-д хүрсэн тохиолдолд Хороонд нэн даруй мэдэгдэх бөгөөд ийнхүү мэдэгдсэнээс хойш даатгагч нь энэ журмын 4.1.2, 4.1.3-г заасан төлөвлөгөөг ажлын 15 хоногийн дотор боловсруулж, Хороонд хүргүүлнэ.

3.9. Даатгагч энэ журмын 2.1-д заасан даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны үзүүлэлт буюу даатгагчийн хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа болон даатгагчийн зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн харьцаа үзүүлэлтүүдийн Хороонд хянагдсан дүнг энэ журмын хорин гуравдугаар хавсралтад заасан загварт нийцүүлэн, 1-3 дугаар улирлын дүнг дараа улирлын 2 дахь сарын 15-ны өдрийн дотор, жилийн эцсийн дүнг 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор өөрийн цахим хуудасны тусгайлсан цэсэнд байршуулан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.

3.10. Даатгагч нь хөрөнгийг гадаад улсад байршуулах бол Хороонд холбогдох үндэслэл бүхий тайлбар, мэдээллийг албан бичгээр ирүүлэх ба даатгагч бүрэн гүйцэд мэдээлэл, тайлбар ирүүлсэн өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор Хороо мэдээллийг хянаж, хариуг албан бичгээр даатгагчид хүргүүлнэ. Хороо шаардлагатай тохиолдолд уг албан бичгийг хүргүүлэх хугацааг сунгаж болно.

Дөрөв. Хяналт, хариуцлага

4.1. Хороо энэ журмын 2.19.1 – 2.19.5-д заасан даатгагчийн төлбөрийн чадварын түвшингээс хамааран дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.1. Даатгагчийн төлбөрийн чадвар нэгдүгээр түвшинд байвал Хороо зайны хяналтыг хэвийн хэрэгжүүлэх;

4.1.2. Даатгагчийн төлбөрийн чадвар хоёрдугаар түвшинд хүрсэн тохиолдолд төлбөрийн чадварын түвшинг сайжруулах төлөвлөгөө болон шаардлагатай гэж үзсэн бусад баримт материалыг Хороонд ирүүлж хянуулахыг шаардах бөгөөд шаардлагатай тохиолдолд газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх;

4.1.3. Даатгагчийн төлбөрийн чадвар гуравдугаар түвшинд хүрсэн тохиолдолд даатгагчаас нэн даруй эрсдэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авах буюу төлбөрийн чадварын түвшинг сайжруулах төлөвлөгөөг боловсруулан, шаардлагатай гэж үзсэн бусад баримт материалын хамт Хороонд ирүүлж хянуулахыг шаардах бөгөөд шаардлагатай тохиолдолд газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх;

4.1.4. Даатгагчийн төлбөрийн чадвар дөрөвдүгээр түвшинд хүрсэн тохиолдолд газар дээрх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, уг түвшинг сайжруулах боломж нөхцөл, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлж буй нөхцөл байдалтай уялдуулан Даатгалын тухай хуулийн 68 дугаар зүйлд заасан албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4.1.5. Даатгагчийн төлбөрийн чадвар тавдугаар түвшинд хүрсэн тохиолдолд уг түвшинг сайжруулах боломж нөхцөл, даатгуулагчдын эрх ашигт ноцтой нөлөөлөх эсэхийг харгалзан үзэж Даатгалын тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1.1, 68.1.2, 68.1.5, 78 дугаар зүйлийн 78.5 дахь заалтад заасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх;

4.1.6. Даатгагчид даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсон улирлаас эхлэн 12 дахь улирлыг дуусталх хугацаанд тухайн даатгагчийн төлбөрийн чадварын түвшин энэ журмын 2.19.4, 2.19.5-д заасан түвшинд хүрсэн тохиолдолд, энэ журмын 4.1.3-г заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.2. Даатгагч энэ журмын 4.1.2, 4.1.3-г заасан төлөвлөгөөг даатгагчийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулсан байх бөгөөд уг төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.2.1.Төлбөрийн чадварт хамгийн их хэмжээгээр эсхүл мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлсэн эрсдэл, үзүүлэлтүүдийг тодорхойлсон байх;

4.2.2.Энэ журмын 1.2-т заасан эрсдэл, түүнд холбогдох эрсдэл, үзүүлэлтүүдийг үе шаттайгаар хэрхэн бууруулах талаар тодорхой баримт, тоо мэдээлэл, загварчлал, тооцоолол дээр үндэслэн тодорхойлсон байх ба эдгээр нь даатгагчийн бусад эрсдэл, хөрөнгийн үзүүлэлтүүд, даатгагчийн үйл ажиллагаа, түүний эрсдэлийн удирдлагын бодлогод хэрхэн нөлөөлөх талаар тусгасан байх;

4.2.3.Төлбөрийн чадварын түвшинг хамгийн ихдээ хоёр улирлын дотор сайжруулахаар төлөвлөгөөний хугацааг товлосон байх бөгөөд даатгагч энэ хугацааг сунгах талаар үндэслэл бүхий хүсэлт, холбогдох баримт нотолгоог ирүүлсэн тохиолдолд нэг удаа сунгаж болно.

4.3.Хороо энэ журмын 4.1.2, 4.1.3-т заасан төлөвлөгөөг ажлын 10 хоногийн дотор хянаж, шаардлагатай тохиолдолд даатгагчид зөвлөмж хүргүүлэн, тус төлөвлөгөөний дагуу ажиллаж буй эсэхэд хяналт тавина.

4.4.Даатгагч Хорооноос тогтоосон хугацаанд энэ журмын 4.1.2, 4.1.3-т заасан төлөвлөгөөг ирүүлээгүй, ирүүлсэн төлөвлөгөө нь энэ журмын 4.2-т заасан шаардлагыг хангаагүй, мөн төлөвлөгөөг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд даатгагчаас ажлын 5 хоногийн дотор тайлбар авах ба үндэслэл бүхий тайлбар ирүүлсэн эсэхээс шалтгаалан Даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.5.Хороо энэ журмын хэрэгжилтэд байнга хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--oOo--

“Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт,
түүнд хяналт тавих журам”-ын
нэгдүгээр хавсралт

МАЯГТ СЗХ04155. ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН ТАЙЛАН

Даатгагчийн нэр.....

20.. оны ... сарын ..-ны өдөр

№	Хөрөнгийн ангилал	Мөрийн дугаар	Эрсдэлийн хувь	Хөрөнгийн дүн*	Эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн 3 = 1*2
А	Б	В	1	2	3 = 1*2
1	Хүүгийн эрсдэл (=мөр(2+...+5))	1			
1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2	1.00%		
1.2	3 сараас 1 жилийн хугацаатай байршуулсан хөрөнгө, хөрөнгө оруулалт	3	3.00%		
1.3	1-5 жилийн хугацаатай байршуулсан хөрөнгө, хөрөнгө оруулалт**	4	7.00% 4.00%		
1.4	5 ба түүнээс дээш жилийн хугацаатай байршуулсан хөрөнгө, хөрөнгө оруулалт**	5	10.00% 6.00%		
2	Валютын ханшийн эрсдэл (=мөр(7+16+25+34+43+52+61+70+79))	6			
2.1	<i>АНУ доллар</i> (= мөр(12+...+15-8...-11))	7			
2.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8	7.40%		
2.1.2	Хадгаламж, хадгаламжийн сертификат	9	7.40%		
2.1.3	Үнэт цаас	10	7.40%		
2.1.4	Давхар даатгалаас авах авлага	11	7.40%		
2.1.5	Хойшлогдсон давхар даатгалын хураамж	12	7.40%		
2.1.6	Даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардал	13	7.40%		
2.1.7	Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг	14	7.40%		
2.1.8	Давхар даатгагчид өгөх өглөг	15	7.40%		
2.2	<i>Евро</i> (= мөр(21+...+24-17...-20))	16			
2.2.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	17	6.43%		
2.2.2	Хадгаламж, хадгаламжийн сертификат	18	6.43%		
2.2.3	Үнэт цаас	19	6.43%		
2.2.4	Давхар даатгалаас авах авлага	20	6.43%		
2.2.5	Хойшлогдсон давхар даатгалын хураамж	21	6.43%		
2.2.6	Даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардал	22	6.43%		
2.2.7	Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг	23	6.43%		

2.2.8	Давхар даатгагчид өгөх өглөг	24	6.43%		
2.3	<i>Японы иен</i> (= мөр(30+...+33-26...-29))	25			
2.3.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	26	6.99%		
2.3.2	Хадгаламж, хадгаламжийн сертификат	27	6.99%		
2.3.3	Үнэт цаас	28	6.99%		
2.3.4	Давхар даатгалаас авах авлага	29	6.99%		
2.3.5	Хойшлогдсон давхар даатгалын хураамж	30	6.99%		
2.3.6	Даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардал	31	6.99%		
2.3.7	Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг	32	6.99%		
2.3.8	Давхар даатгагчид өгөх өглөг	33	6.99%		
2.4	<i>Английн фунт</i> (= мөр(39+...+42-35...-38))	34			
2.4.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	35	7.41%		
2.4.2	Хадгаламж, хадгаламжийн сертификат	36	7.41%		
2.4.3	Үнэт цаас	37	7.41%		
2.4.4	Давхар даатгалаас авах авлага	38	7.41%		
2.4.5	Хойшлогдсон давхар даатгалын хураамж	39	7.41%		
2.4.6	Даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардал	40	7.41%		
2.4.7	Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг	41	7.41%		
2.4.8	Давхар даатгагчид өгөх өглөг	42	7.41%		
2.5	<i>ОХУ-ын рубль</i> (= мөр(48+...+51-44...-47))	43			
2.5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	44	10.90%		
2.5.2	Хадгаламж, хадгаламжийн сертификат	45	10.90%		
2.5.3	Үнэт цаас	46	10.90%		
2.5.4	Давхар даатгалаас авах авлага	47	10.90%		
2.5.5	Хойшлогдсон давхар даатгалын хураамж	48	10.90%		
2.5.6	Даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардал	49	10.90%		
2.5.7	Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг	50	10.90%		
2.5.8	Давхар даатгагчид өгөх өглөг	51	10.90%		
2.6	<i>БНХАУ-ын юань</i> (= мөр(57+...+60-53...-56))	52			
2.6.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	53	8.29%		
2.6.2	Хадгаламж, хадгаламжийн сертификат	54	8.29%		
2.6.3	Үнэт цаас	55	8.29%		
2.6.4	Давхар даатгалаас авах авлага	56	8.29%		
2.6.5	Хойшлогдсон давхар даатгалын хураамж	57	8.29%		
2.6.6	Даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардал	58	8.29%		

2.6.7	Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг	59	8.29%		
2.6.8	Давхар даатгагчид өгөх өглөг	60	8.29%		
2.7	<i>БНСУ-ын вон</i> (= мөр(66+...+69-62...-65))	61			
2.7.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	62	4.92%		
2.7.2	Хадгаламж, хадгаламжийн сертификат	63	4.92%		
2.7.3	Үнэт цаас	64	4.92%		
2.7.4	Давхар даатгалаас авах авлага	65	4.92%		
2.7.5	Хойшлогдсон давхар даатгалын хураамж	66	4.92%		
2.7.6	Даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардал	67	4.92%		
2.7.7	Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг	68	4.92%		
2.7.8	Давхар даатгагчид өгөх өглөг	69	4.92%		
2.8	<i>Хонконг доллар</i> (= мөр(75+...+78-71...-74))	70			
2.8.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	71	7.54%		
2.8.2	Хадгаламж, хадгаламжийн сертификат	72	7.54%		
2.8.3	Үнэт цаас	73	7.54%		
2.8.4	Давхар даатгалаас авах авлага	74	7.54%		
2.8.5	Хойшлогдсон давхар даатгалын хураамж	75	7.54%		
2.8.6	Даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардал	76	7.54%		
2.8.7	Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг	77	7.54%		
2.8.8	Давхар даатгагчид өгөх өглөг	78	7.54%		
2.9	<i>Бусад улсын валют</i> (= мөр(84+...+87-80...-83))	79			
2.9.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	80	7.40%		
2.9.2	Хадгаламж, хадгаламжийн сертификат	81	7.40%		
2.9.3	Үнэт цаас	82	7.40%		
2.9.4	Давхар даатгалаас авах авлага	83	7.40%		
2.9.5	Хойшлогдсон давхар даатгалын хураамж	84	7.40%		
2.9.6	Даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардал	85	7.40%		
2.9.7	Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг	86	7.40%		
2.9.8	Давхар даатгагчид өгөх өглөг	87	7.40%		
3	Хувьцааны эрсдэл*** (=мөр(89+...+97))	88			
3.1.	Компанийн нэгдлийн оролцогч компаниудад**** оруулсан хөрөнгө оруулалт	89	45.00%		
3.2	Компанийн нэгдлийн оролцогч компаниудад оруулсан хөрөнгө оруулалтад үл хамаарах хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа	90	45.00%		

3.3	Компанийн нэгдлийн оролцогч компаниудад оруулсан хөрөнгө оруулалтад үл хамаарах нээлттэй хувьцаат компанийн хувьцаа	I ангилал	91	25.00%		
		II ангилал	92	30.00%		
		III ангилал	93	40.00%		
3.4	Компанийн нэгдлийн оролцогч компаниудад оруулсан хөрөнгө оруулалтад үл хамаарах хаалттай хувьцаат компанийн хувьцаа		94	37.50%		
3.5	Гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн нээлттэй арилжаалагддаг хувьцаа		95	46.50%		
3.6	Гадаад улсын биржийн бус зах зээл дээр бүртгэлтэй компанийн хувьцаа		96	56.50%		
3.7	Бусад хувьцаа		97	60.00%		
4	Хөрөнгийн эрсдэл (=мөр(99+...+117))		98			
4.1	Газрын сайжруулалт*****		99	5.00%		
4.2	Барилга байгууламж*****		100	15.00%		
4.3	Машин тоног төхөөрөмж		101	20.00%		
4.4	Тээврийн хэрэгсэл		102	35.00%		
4.5	Тавилга эд хогшил		103	40.00%		
4.6	Компьютер дагалдах хэрэгсэл		104	45.00%		
4.7	Санхүүгийн түрээсийн хөрөнгө		105	15.00%		
4.8	Дуусаагүй барилга		106	50.00%		
4.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө*****		107	15.00%		
4.10	Үнэт металл, Дериватив		108	30.00%		
4.11	Барьцаалсан хөрөнгө*****		109	80.00%		
4.12	Виртуал хөрөнгө*****		110	90.00%		
4.13	Бараа материал		111	70.00%		
4.14	Өмчлөх бусад хөрөнгө	Хэвийн	112	0.00%		
		Анхаарал хандуулах	113	25.00%		
		Хэвийн бус	114	50.00%		
		Эргэлзээтэй	115	100.00%		
		Муу	116	100.00%		
4.15	Биет бус хөрөнгө		117	50.00%		

*энэ журмын хорьдугаар хавсралтад тусгагдсан дансны жагсаалтаарх хөрөнгийн ангиллын дүнг ашиглана.

**энэ журмын хоёрдугаар хавсралтад заасны дагуу тооцсон хөрөнгө ба өр төлбөрийн хугацааны зөрүү 0-с их тохиолдолд 1-5 жилийн хугацаатай байршуулсан хөрөнгө, хөрөнгө оруулалтын хүүгийн эрсдэлийн хувьд 7.00%, 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай байршуулсан хөрөнгө, хөрөнгө оруулалтын хувьд 10.00%, харин хөрөнгө ба өр төлбөрийн хугацааны зөрүү 0 ба түүнээс бага тохиолдолд 1-5 жилийн хугацаатай байршуулсан хөрөнгө, хөрөнгө оруулалтын хүүгийн

эрсдэлийн хувьд 4.00%, 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай байршуулсан хөрөнгө, хөрөнгө оруулалтын хувьд 6.00% эрсдэлийн хувийг ашиглана.

*** Хувьцаанд хөрвөх нөхцөлтэй өрийн бичиг, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх энэ ангилалд хамаарна.

**** Даатгагч нь Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.16 дахь хэсэгт заасан компанийн нэгдлийн оролцогч компани тохиолдолд холбогдох ангилалд хамаарах хөрөнгийн дүнг тусгана.

***** Иргэний хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3 дахь хэсэгт заасан, холбогдох хууль, журмын дагуу баталгаажсан эрхийн гэрчилгээтэй үл хөдлөх хөрөнгө энэ ангилалд хамаарна.

***** энэ маягтын 4.11-д заасан холбогдох хууль тогтоомжийн дагуу барьцаалсан эд хөрөнгө, 4.12-т заасан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан хөрөнгө нь нягтлан бодох бүртгэлийн хувьд энэ маягтын 4-т заасан бусад хөрөнгийн дүнд бүртгэгдсэн тохиолдолд уг бүртгэгдсэн хөрөнгийн дүнг 4.11, 4.12-т заасан хөрөнгийн дүнгээр бууруулж тооцно.

Тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН:

Гүйцэтгэх захирал	/...../	/...../
Ерөнхий нягтлан бодогч	/...../	/...../
.....	/...../	/...../

“Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт,
түүнд хяналт тавих журам”-ын
хоёрдугаар хавсралт

МАЯГТ СЗХ04156. ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨРИЙН ХУГАЦААНЫ ЗӨРҮҮ

Даатгагчийн нэр.....

20.. оны ... сарын ..-ны өдөр

№	Үзүүлэлт	Мөрийн дугаар	Хөрөнгийн дүн*	Өр төлбөрийн дүн**
А	Б	В	1	2
1.1	0-1 жилийн хугацаатай	1		
1.2	1-5 жилийн хугацаатай	2		
1.3	5 ба түүнээс дээш жилийн хугацаатай	3		
1.4	Хугацааны дундаж үзүүлэлт***	4		
1.5	Хөрөнгө ба өр төлбөрийн хугацааны зөрүү (=мөр 4 багана(1-2))	5		

*0-1 жилийн хугацаатай хөрөнгийн дүнгийн хувьд энэ журмын нэгдүгээр хавсралтад тусгагдсан Хүүгийн эрсдэлийн Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө болон 3 сараас 1 жилийн хугацаатай байршуулсан хөрөнгө, хөрөнгө оруулалтын нийлбэр дүнг ашиглана. 1-5, 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай хөрөнгийн дүнгийн хувьд энэ журмын нэгдүгээр хавсралтад тусгагдсан Хүүгийн эрсдэлийн 1-5, 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай байршуулсан хөрөнгө, хөрөнгө оруулалтын дүнг тус тус ашиглана.

**энэ журмын 3.2.7-д заасан маягтын дагуу тооцсон даатгагчийн өр төлбөрийн дүнг ашиглана.

***хугацааны ангилал бүрийн дундаж утга, хөрөнгө болон өр төлбөрийн дүнгийн жигнэсэн дунджийг ашиглан хугацааны дундаж үзүүлэлтийг тооцно.

Тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН:

Гүйцэтгэх захирал /...../ /...../

Ерөнхий нягтлан бодогч /...../ /...../

..... /...../ /...../

“Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт,
түүнд хяналт тавих журам”-ын
гуравдугаар хавсралт

МАЯГТ СЗХ04157. ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН ХАМААРЛЫН ТООЦООЛОЛ

Даатгагчийн нэр.....

20.. оны ... сарын ..-ны өдөр

i \ j		Хүүгийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн	Валютын ханшийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн	Хувьцааны эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн	Хөрөнгийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн
		Зах зээлийн эрсдэлийн хамаарлын коэффициент			
Хүүгийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн		1.00	0.25	-	-
Валютын ханшийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн		0.25	1.00	0.25	-
Хувьцааны эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн		-	0.25	1.00	-
Хөрөнгийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн		-	-	-	1.00
Зах зээлийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн					

тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН:

Гүйцэтгэх захирал /...../ /...../

Ерөнхий нягтлан бодогч /...../ /...../

..... /...../ /...../

“Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт,
түүнд хяналт тавих журам”-ын
дөрөвдүгээр хавсралт

МАЯГТ СЗХ04158. ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН ТАЙЛАН

Даатгагчийн нэр.....

20.. оны ... сарын ..-ны өдөр

№	Үзүүлэлт	Мөрийн дугаар	Эрсдэлийн хувь	Хөрөнгийн дүн*	Эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн 3=1*2
А	Б	В	1	2	3=1*2
1	Дотоодын банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө** (=мөр(2+11))	1			
1.1	Дотоодын банкин дахь харилцах, хадгаламж, хадгаламжийн сертификат (=мөр(3+...+10))	2			
1.1.1	Батлан даалттай	3	0.00%		
1.1.2	АА ба түүнээс дээш	4	2.00%		
1.1.3	А	5	5.00%		
1.1.4	ВВВ	6	6.00%		
1.1.5	ВВ	7	7.00%		
1.1.6	В ба түүнээс доош	8	8.00%		
1.1.7	Зэрэглэлгүй	9	10.00%		
1.1.8	Бусад	10	80.00%		
1.2	Дотоодын банкнаас бусад санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (=мөр(12+...+19))	11			
1.2.1	Батлан даалттай	12	0.00%		
1.2.2	АА ба түүнээс дээш	13	5.00%		
1.2.3	А	14	7.00%		
1.2.4	ВВВ	15	10.00%		
1.2.5	ВВ	16	12.00%		
1.2.6	В ба түүнээс доош	17	14.00%		
1.2.7	Зэрэглэлгүй	18	16.00%		
1.2.8	Бусад	19	80.00%		
2	Даатгалын авлага /давхар даатгагчаас авах авлагаас бусад/ (цэвэр) (=мөр(21+...+25))	20			
2.1	Хэвийн	21	0.00%		
2.2	Анхаарал хандуулах	22	25.00%		
2.3	Хэвийн бус	23	50.00%		
2.4	Эргэлзээтэй	24	100.00%		
2.5	Муу	25	100.00%		
3	Давхар даатгагчаас авах авлага*** (цэвэр) (=мөр(27+...+34))	26			
3.1	Батлан даалттай****	27	0.00%		
3.2	АА ба түүнээс дээш	28	1.60%		

3.3	А	29	4.00%		
3.4	BBB	30	8.00%		
3.5	BB	31	16.00%		
3.6	В ба түүнээс доош	32	24.00%		
3.7	Зэрэглэлгүй, хамгаалалттай	33	30.00%		
3.8	Зэрэглэлгүй, хамгаалалтгүй	34	100.00%		
4	Бусад авлага (цэвэр) (=мөр(36+...+40))	35			
4.1	Хэвийн	36	0.00%		
4.2	Анхаарал хандуулах	37	25.00%		
4.3	Хэвийн бус	38	50.00%		
4.4	Эргэлзээтэй	39	100.00%		
4.5	Муу	40	100.00%		
5	Гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (=мөр(42+...+49))	41			
5.1	Батлан даалттай	42	0.00%		
5.2	AA ба түүнээс дээш	43	1.60%		
5.3	А	44	2.00%		
5.4	BBB	45	4.00%		
5.5	BB	46	8.00%		
5.6	В ба түүнээс доош	47	12.00%		
5.7	Зэрэглэлгүй, хамгаалалттай	48	20.00%		
5.8	Зэрэглэлгүй, хамгаалалтгүй	49	70.00%		
6	Хойшлогдсон давхар даатгалын хураамж*** (=мөр(51+...+58))	50			
6.1	Батлан даалттай	51	0.00%		
6.2	AA ба түүнээс дээш	52	1.60%		
6.3	А	53	4.00%		
6.4	BBB	54	8.00%		
6.5	BB	55	16.00%		
6.6	В ба түүнээс доош	56	24.00%		
6.7	Зэрэглэлгүй, хамгаалалттай	57	30.00%		
6.8	Зэрэглэлгүй, хамгаалалтгүй	58	100.00%		
7	Нөхөн төлбөрийн нөөцийн сангийн давхар даатгагчид ногдох хэсэг**** (=мөр(60+...+65))	59			
7.1	Батлан даалттай	60	0.00%		
7.2	AA ба түүнээс дээш	61	1.60%		
7.3	А	62	4.00%		
7.4	BBB	61	8.00%		
7.5	BB	62	16.00%		
7.6	В ба түүнээс доош	63	24.00%		
7.7	Зэрэглэлгүй, хамгаалалттай	64	30.00%		
7.8	Зэрэглэлгүй, хамгаалалтгүй	65	100.00%		
8	Даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардал**** (=мөр(67+...+74))	66			
8.1	Батлан даалттай	67	0.00%		
8.2	AA ба түүнээс дээш	68	1.60%		
8.3	А	69	4.00%		
8.4	BBB	70	8.00%		

8.5	ВВ	71	16.00%		
8.6	В ба түүнээс доош	72	24.00%		
8.7	Зэрэглэлгүй, хамгаалалттай	73	30.00%		
8.8	Зэрэглэлгүй, хамгаалалтгүй	74	100.00%		
9	Үнэт цаас (цэвэр) (=мөр(76+...+94+103+112+121))	75			
9.1	Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл	76	0.00%		
9.2	Хөгжлийн банкны үнэт цаас	77	5.00%		
9.3	Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл	78	5.00%		
9.4	Ногоон бонд	79	10.00%		
9.5	Хөрөнгөөр баталгаажсан барьцаат үнэт цаас	80	6.00%		
9.6	Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас	81	8.00%		
9.7	Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн өрийн хэрэгсэл – I ангилал	82	10.00%		
9.8	Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн өрийн хэрэгсэл – II ангилал	83	12.50%		
9.9	Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн өрийн хэрэгсэл – III ангилал	84	15.00%		
9.10	Компанийн өрийн хэрэгсэл – биржийн бус зах зээл дээр арилжаалагддаг	85	20.00%		
9.11	Хамтын хөрөнгө оруулалтын нээлттэй сангийн нэгж эрх	86	10.00%		
9.12	Хамтын хөрөнгө оруулалтын хаалттай сангийн нэгж эрх	87	15.00%		
9.13	Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	88	20.00%		
9.14	Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	89	20.00%		
9.15	Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – I ангилал	90	20.00%		
9.16	Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – II ангилал	91	25.00%		
9.17	Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – III ангилал	92	30.00%		
9.18	Хаалттай хувьцаат болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа	93	40.00%		
9.19	Гадаадын Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл (=мөр(95+...+102))	94			
9.19.1	Батлан даалттай	95	0.00%		
9.19.2	АА ба түүнээс дээш	96	1.60%		
9.19.3	А	97	2.00%		
9.19.4	ВВВ	98	4.00%		
9.19.5	ВВ	99	8.00%		

9.19.6	В ба түүнээс доош	100	12.00%		
9.19.7	Зэрэглэлгүй, хамгаалалттай	101	18.00%		
9.19.8	Зэрэглэлгүй, хамгаалалтгүй	102	50.00%		
9.20	Гадаадын компанийн өрийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын сан (=мөр(104+...+111))	103			
9.20.1	Батлан даалттай	104	0.00%		
9.20.2	АА ба түүнээс дээш	105	2.00%		
9.20.3	А	106	4.00%		
9.20.4	ВВВ	107	8.00%		
9.20.5	ВВ	108	16.00%		
9.20.6	В ба түүнээс доош	109	24.00%		
9.20.7	Зэрэглэлгүй, хамгаалалттай	110	50.00%		
9.20.8	Зэрэглэлгүй, хамгаалалтгүй	111	100.00%		
9.21	Гадаадын компанийн хувьцаа (=мөр(113+...+120))	112			
9.21.1	Батлан даалттай	113	4.00%		
9.21.2	АА ба түүнээс дээш	114	8.00%		
9.21.3	А	115	16.00%		
9.21.4	ВВВ	116	24.00%		
9.21.5	ВВ	117	30.00%		
9.21.6	В ба түүнээс доош	118	50.00%		
9.21.7	Зэрэглэлгүй, хамгаалалттай	119	100.00%		
9.21.8	Зэрэглэлгүй, хамгаалалтгүй	120	100.00%		
9.22	Бусад үнэт цаас	121	100.00%		

*энэ журмын хорин нэгдүгээр хавсралтад тусгагдсан дансны жагсаалтаарх хөрөнгийн ангиллын дүнг ашиглана.

** энэ маягтын 1.1-д заасан дотоодын банк нь Монгол банкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-т заасан шаардлагыг хангасан банк байх, 1.2-т заасан банкнаас бусад санхүүгийн байгууллага нь Хорооноос санхүүгийн үйлчилгээний чиглэлээр тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй байх ба банк бус санхүүгийн байгууллагын хувьд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг хангасан банк бус санхүүгийн байгууллага байх, эдгээр шаардлагуудыг хангаагүй дотоодын банк, банкнаас бусад санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, хөрөнгө оруулалтын дүнг энэ маягтын 1.1.8, 1.2.8 заалтад буюу 10, 19 дүгээр мөрийн 2 дугаар баганын харгалзах нүдэнд тус тус тусгана.

*** Давхар даатгагч нь дотоодын төрийн өмчит хувьцаат компани тохиолдолд энэ маягтын 3, 6, 7 дахь үзүүлэлтийн хувьд эрсдэлийн хувийг 4 хувиар тооцно.

**** Даатгалын зуучлагч, төлөөлөгч нь дотоодын хуулийн этгээд, иргэн тохиолдолд энэ маягтын 8 дахь үзүүлэлтийн эрсдэлийн хувийг 4 хувиар тооцно.

Тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН:

Гүйцэтгэх захирал /...../ /...../

Ерөнхий нягтлан бодогч /...../ /...../

..... /...../ /...../

“Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт,
түүнд хяналт тавих журам”-ын
тавдугаар хавсралт

МАЯГТ СЗХ04159. ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН ХАМААРЛЫН ТООЦООЛОЛ

Даатгагчийн нэр.....

20.. оны ... сарын ..-ны өдөр

i \ j	Дотоодын банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн	Даатгалын авлагын эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн	Давхар даатгагчаас авах авлагын эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн	Бусад авлагын эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн	Гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн	Хойшлогдсон давхар даатгалын хураамжийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн	Нөхөн төлбөрийн нөөцийн сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн	Даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардлын эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн	Үнэт цаасны эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн
	Зээлийн эрсдэлийн хамаарлын коэффициент								
Дотоодын банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн эрсдэлд хөрөнгийн суурилсан дүн	1.00	-	-	-	-	-	-	-	-
Даатгалын авлагын эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн	-	1.00	-	-	-	-	-	-	-
Давхар даатгагчаас авах авлагын эрсдэлд	-	-	1.00	-	-	0.50	0.50	-	-

суурилсан хөрөнгийн дүн										
Зээлийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн										

тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН:

Гүйцэтгэх захирал	/...../	/...../
Ерөнхий нягтлан бодогч	/...../	/...../
.....	/...../	/...../

“Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт,
түүнд хяналт тавих журам”-ын
зургаадугаар хавсралт

МАЯГТ СЗХ04160. ЕРДИЙН ДААТГАЛЫН АНДЕРРАЙТИНГИЙН ЭРСДЭЛИЙН ТАЙЛАН

Даатгагчийн нэр.....

20.. оны ... сарын ..-ны өдөр

№	Даатгалын хэлбэр	Мөрийн дугаар	Эрсдэлийн хувь	Хөрөнгийн дүн*	Эрсдэлд суурилсан хөрөнгө
А	Б	В	1	2	3=1*2
1	Хураамжийн эрсдэл (=мөр(2+...+19))	1			
1.1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	2	40.00%		
1.2	Хөрөнгийн даатгал	3	20.00%		
1.3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	4	20.00%		
1.4	Ачааны даатгал	5	34.00%		
1.5	Барилга угсралтын даатгал	6	65.00%		
1.6	Газар тариалангийн даатгал	7	80.00%		
1.7.a	Малын индексжүүлсэн даатгал	8	20.00%		
1.7.6	1.7.a-аас бусад мал амьтдын даатгал	9	45.00%		
1.8	Агаарын хөлгийн даатгал	10	60.00%		
1.9	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	11	30.00%		
1.10	Хариуцлагын даатгал	12	40.00%		
1.11	Санхүүгийн даатгал	13	35.00%		
1.12	Зээлийн даатгал	14	60.00%		
1.13	Итгэлцлийн даатгал	15	40.00%		
1.14	Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	16	60.00%		
1.15	Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	17	20.00%		
1.16	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	18	20.00%		
1.17	Жолоочийн хариуцлагын даатгал	19	15.00%		
2	Нөхөн төлбөрийн эрсдэл (=мөр(21+...+38))	20			
2.1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	21	20.00%		
2.2	Хөрөнгийн даатгал	22	60.00%		
2.3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	23	20.00%		
2.4	Ачааны даатгал	24	35.00%		
2.5	Барилга угсралтын даатгал	25	65.00%		
2.6	Газар тариалангийн даатгал	26	60.00%		
2.7.a	Малын индексжүүлсэн даатгал	27	20.00%		
2.7.6	2.7.a-аас бусад мал амьтдын даатгал	28	60.00%		
